

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2017.03.21**

Тендер шалгаруулалтын нэр: **“Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажил /Улаанбаатар/”**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЭХА-2017/05-42**

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажил, ЭХА-2017/05-42”-ыг** гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **150,000** төгрөгөөр худалдан авч болно.

Төрийн сан банкин дахь Эрчим хүчний яамны 100900030003 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тухайн багцын төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил “2015, 2016”**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

- **Эрчим хүчний сайдын “03.2.2: 0.4-15кВ-ын цахилгаан түгээх шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ”**
- **03.9.3: Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах 0.4-35 кВ эсхүл 1.2.5 Дотор гэрэлтүүлэг цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл) тусгай зөвшөөрөлтэй байна.**

Тендерийн хамт 3,125,000 төгрөгний дүнтэй тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн, 10 цаг 50 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.
Чингисийн өргөн чөлөө. Эрчим хүчний яам.
Засгийн газрын ХИҮ байр. 3 давхар. 306 тоот өрөө.
www.energy.gov.mn